

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255019>

СОНГОДОГ МОНГОЛ БИЧИГИЙХЭЭ УЛАМЖИЛАЛЫГ  
ХАДГАЛАЯ<sup>1</sup>

Д.Төмөртогоо

**Хураангуй.** Монгол бичиг бол уйгур бичигээс уламжилалтай бөгөөд уулаас арван дөрөвхөн үсэгтэй уйгур бичигийг монголчууд хэл аялгуундаа тохируулан нэмэн зассаар 14 зууны эхээр 123 үе-үсэгтэй, харьцангуй боловсоронгуй дүрэм зүйтэй болгож, хөшөө чулууны бичээс, барын болон гар бичмэл ном зохиол, бичиг захидал, пайз, тамганы бичиг олонг үлдээжээ. Монголчууд үсэг бичигээ тасаралгүй сайжируулсаар 18 зууны үе болоход боловсоронгуй бичигийн хэлтэй болж, бурханы шашины сургаал номлол, бүддийн гүн ухаан, хэл шинжилэл, түүх шастир, хууль цааз, утга зохиолын зуу зуун боть ном зохиол хэвлэн гаргаж, арвин их гар бичмэл даанс эвхэмэл, бичиг захидал үлдээсэн нь сонгодог монгол бичигийн үнэт дурасхал болж байгаа билээ. Гэтэл сүүлийн үед монгол бичигийнхээ сонгодог уламжилалыг гажуудуулан, ярианы хэлэндээ ойртуулах гэсэн өнгөц хандлага бий болсоноос үгийн язгуур, үндэс, дагавар, нөхцөлийн бүтэцийг эвдэж бичих болжээ. Хойшид монгол бичигийнхээ сонгодог уламжилалыг хадгалан бичигийн хэлнийхээ тогтсон дүрэмийг чанд баримтлах нь зүйтэй.

**Түлхүүр үг:** Хэлний бүтэц, тогтолцоо ба бичигийн хэл. Сонгодог монгол бичигийн уламжилал. Бичигийн хэлийг хилбарчилах хандлага. Хилбарчилах хандлагаас татгалзая.

**Keywords:** Structure and system of written language, Tradition of classical Mongolian, Attitudes toward simplification, Rejection of the simplifying attitude.

Бидний өвөг дээдэс Хүннүгийн үеэс Сяньби, Жүжаан, Тобагийн үеийг дамжин Хитан гүрэний үеийг хүртэл олон зуун жилийн турш хитад утгын бичигийг үеийн бичигийн тогтолцоонд оруулж, дуудлагыг нь ашиглан хэлнийхээ авиаг тэмдэглэж байжээ. Хэдий тийм боловч тэдний хэрэглэж байсан үсэг бичигийн аль нь ч нарийн тогтсон дүрэм зүйтэй үндэсний бичиг болж чадалгүй, тухай тухайн үеийнхээ үсэг бичигийн хэрэглээг ямар нэг хэмжээгээр хангаж байжээ.

IX-X зууны үед Уйгурын хаант улсын мандан хөгжиж байсан тэр үед хил залгаа монгол аймагууд тэдний хэрэглэж байсан согд гаралтай уйгур бичигийг зээлдэн авч, цөөн аймагийн хүрээнд хэрэглэж байжээ. Хожим Их Монгол гүрэн үүсэн бүрэлдэж, түүнд багтаж байсан олон монгол аймаг улс төр, шашин, соёлынхоо талаар бие биетэйгээ ойртохын сацуу анх цөөн аймагийн бичигийн хэрэгцээнд үйлчилж байсан уйгур бичигийн хэрэглээний цар хүрээ үлэмжхэн өргөжин тэлж, уламаар нийт монголчуудын бичигийн хэлний үүрэгийг гүйцэдхэх болсон байна.

Уулаас арван дөрөвхөн үсэгтэй уйгур бичиг нь монгол хэлний авиа дуудлагыг бүрэн тэмдэглэхэд хүрэлцээгүй байсан тул түүнийг хэл аялгууныхаа онцлогт

<sup>1</sup> Энэхүү өгүүллийн бичвэрийг “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” бичгийн дүрмийг дагалгүй Академич Д.Төмөртогоогийн өөрийнх нь баримталдаг зарчмыг тэр хэвээр хадгалж хэвлэв.

тохируулан нэмэж засах шаардлага урган гарсан тул уйгур үсэгийг нэмэн засаж, туршин хэрэглэх ажил гурван зуу гаруй жил үргэлжилсээр XIII зуунтай золгожээ. XIII зууны дундуур Сажа бандида Гүнгаажалцан уйгуржин бичигийг монгол хэл аялгууны тогтолцоонд ойртуулан нэмэн дэлгэрүүлж, 100 авиа тэмдэглэх 44 үсэгтэй болгосон төдийгүй тэдгээр үсэгээр холбон бичих дүрэм зүйг багтаасан “*Зүрэхний тольт*” хэмээх хэл зүйн бичиг зохиосон нь эдүгээгийн монгол бичиг хийгээд хэлний зүйн үндэс суурь нь болжээ. XIV зуунд Их Монгол улсын нэгдсэн төр хүчирхэгжиж, төрийн хууль цааз, хаад ноёдын зарлиг айлдхал, ихэс дээдэсийн хөшөө дурасхал зэрэгийг монголоор бичиж сийлэх, нөгөө талаар, бурханы шашины сургаал номлол, судар номууд олоноор хэвлэн гаргах зэрэгээр бичигийн хэлний хэрэгцээ шаардлага үлэмжхэн нэмэгджээ.

Их Монгол улсын наймдугаар их хаан Хайсанхүлэг (1281-1311)-ийн үед Чойжи-Одсэр бандида урид Гүнгаажалцаны зохиосон “*Зүрэхний тольт*” хэмээх хэл зүйн бичигийг нэмэн дэлгэрүүлсэн “*Зүрэхний тольтын тайлбар*” хэмээх хэл зүйн бичиг туурвижээ. Тэрхүү зохиолд монгол бичигийн цагаан толгойн бүрэлдэхүүнийг өргөдхөн нэмээд 123 үе-үсэгтэй болгосон төдийгүй, тэдгээр үсэгээр монгол хэлний авиа дуудлагыг хэрхэн бичих дүрэм хийгээд авианы ангилал, тэдгээрийн байрлал, хэл зүйн нөхцөлүүдийг холбон бичих талаар дэлгэрэнгүй үгүүлсэн нь хожимын бичиг зохиолоор дамжин үлджээ. Нэг талаар, уйгур үсэгийн уламжилалт тиг зурлагыг бараг хэвээр хадгалж, нөгөө талаар, XIII-XIV зууны монгол хэлний бүтэц, тогтолцоог тусхасан дүрэм бүхий уйгур гаралтай тэрхүү бичигийг ‘*уйгуржин монгол үсэг*’ хэмээн нэрийдсээр ирсэн билээ.

Чойжи-Одсэр бандидагийн засан сайжируулж, нэмэн боловсоруулсан уйгуржин монгол үсэгээр Их Монголын хаан Мөнх, Хубилай нарын зарлиг, Ил-хаан Абага, Аргун, Хасан, Өлзийт нарын захидал, Жигүүндэй, Аруг ван, Чан Йин-жүй, Индү зэрэг төрийн зүдхэлтэн хаад ноёдын дурасхалыг хүндэдхэсэн хөшөөний бичээс, “*Банзрагч*”, “*Бодичарьяаватара*”, “*Махагалын магтаал*”, “*Тахимдуу ном*”, “*Бурхан багшийн арван хоёр зохионгуй*”, “*Эрдэнийн сан Субашид*”, “*Сулхарнайн тууж*”, “*Алтан ордоны үйсний бичиг*”, Турфан, Дүнхуан, Аржайн агуйн ханын бичээсүүд зэрэг олон арван үнэт дурасхал бичигдэн үлджээ.

XVI-XVII зууны үеэс Монгол оронд бурханы шашин дахин хүчтэй дэлгэрсэн нь нийгэм, соёлын амьдаралд хүчтэй нөлөөлж, бурханы шашины сургаал номлол болон энэдхэг, төвөдийн сонгодог ухааны зохиол бүтээлүүдийг монгол хэлээр орчуулан хэвлэх ажил эрчимтэй өрнөжээ. Тийнхүү олон тооны ном зохиол хэвлэн гаргахад бичлэгийн дүрэм, хэлний зүйгээ улам сайжируулж, харь хэлний нэр томьёо, үг ухагдахууныг оновчтой зөв буулгах, хэл найруулгаа яруу тодорхой болгох бодит шаардлага урган гарчээ. Тэдгээр шаардлагад нийцсэн хэд хэдэн томоохон ахиц гарчээ. Юуны өмөнө, бандида Гүнгаа-Одсэрийн “*Монголын зуун найман үсэг оршив*”, рабжамба Данзандагвын “*Зүрэхний тольтын тайлбар үсэгийн эндүүрэлийн харанхуйг арилгагч Огторгуйн маань*”, Урад гүүш Билигийндалайн “*Монгол үсэгийн ялгал ба махбодын өчүүхэн товчнууд*” зэрэг бүтээл гарч, тэдгээрт монгол үсэгийн бүрэлдэхүүн, тэдгээрийг залган бичих дүрэм зүй, авианы ангилал, үг холбох ёс зэрэг олон асуудалыг багтаажээ. Мөн Харчины Аюуш гүүш эртний энэдхэгийн ‘*али гали*’ үсэгийн зарчим дээр тулгуурлан ‘*монгол галиг*’ үсэгийг нэмэн зохиосоноор монгол бичигийн үсэгийн бүрэлдэхүүн үлэмжхэн тэлж, санскрит, төвөд нэр томьёо, үг хэллэгийг нарийн зөв тэмдэглэх боломж нэмэгджээ. Түүний зэрэгцээ уйгур үсэгээс уламжилалтай зарим үсэгийн тиг зурлага хийгээд үгийн эцэсийн урт сүүл тэргүүтэнийг өөрчилөн, шинэ тиг дүрсээр хэвшүүлэн тогтоосоноор урид хэрэглэж байсан ‘*уйгуржин монгол бичиг*’ монголчуудын

боловсоруулсан жинхэнэ *‘монгол бичиг’* болж чадсан байна. Түүнчилэн дороно дахины их таван ухааны олон аймаг савын үг хэллэг, нэр томьёоны утгыг дүйлгэн буулгасан *“Мэргэд гарахын орон”* хэмээх толь бичиг болон хэцүү үг хэллэгийг тайлбарласан олон тооны дүймэн гарсан зэрэг нь орчуулгын практик хэрэглээнд үнэтэй хувь нэмэр болсон төдийгүй, монгол бичигийн хэлний үгсийн сангийн бүрэлдэхүүнийг үлэмж баяжуулжээ.

Монгол бичигийн хэлэнд гарсан дээрхи шинэчилэл, өөрчилөлийн үр дүнд дороно дахины их таван ухааны 5500 гаруй зохиолыг багтаасан *“Ганжуур”* (108 боть), *“Данжуур”* (225 боть) тэргүүтэй их хөлгөн сударуудыг сайтар хэвшин тогтсон дүрэмээрээ найруулан бичиж, санскрит, төвөд хэлний олон зуун нэр томьёог монгол галиг үсэгээрээ нарийвчилан буулгаж, жигдлэн тогтоосон байна. Түүнээс гадна *“Алтан товч”*, *“Эрдэнийн товч”*, *“Эрдэнийн эрих”*, *“Болор эрих”*, *“Асарагч нэртийн түүх”* зэрэг олон арван түүхэн сурвалж бичиг, бүддийн гүн ухаан, дуун ухаан, тэжээхүй ухаан, учир шалтгааны ухаан, уран зохиол, иргэний болон шашины магтаал дуулал зэрэг зуу зуун боть зохиолыг хэвлэн гаргасан нь монгол бичигийн хэл сайтар цэгцэрч, жинхэнэ сонгодог бичигийн хэлний зиндаанд хүрсэний жинхэнэ бодьтой баримт болж байгаа билээ.

Монгол бичигийн хэл тийнхүү олон зуун жилийн турш хэвшин тогтож ирэхдээ тухай тухайн үеийнхээ аман ярианы хэлэнд гарсан аливаа хувьсал өөрчилөлтийг даган дууриаж хувиссангүй, анх хэвшин бүрэлдсэн үндсэн шинжээ харьцангуй тогтвортой хадгалсаар иржээ. Тийнхүү тогтвортой хэвшин тогтсон монгол бичигийн хэл нь тасаралтгүй хувьсан өөрчилөгдсөөр ирсэн аман ярианы хэлнээсээ хоцорч, уламаар бичигийн хэл, ярианы хэл хоёрын хоорондын ялгаа зөрөө улам нэмэгдсээр ирсэн бөгөөд ийнхүү зөрөөтэй болох нь бичигийн хэлний хоцорогдол бус, харин ч эх хэлнийхээ олон зуун жилийн өмөнөх хэв шинжийг урт удаан хугацаанд тогтвортой хадгалан үлдсэнээрээ хэлний түүхийн бодит баримт, үнэт дурасхал болсон байна. Тухайлбал, бичигийн хэлэндээ тогтвортой хадгалагдан үлдсэн хэлний шинж нь олон зуун жилийн өмөнөх амид хэлний бодит дуудлагыг тусхаж байгаагаараа тухайн хэлний хөгжилийн цаг хугацаа, хэв шинжийг тогтоох хөдөлшгүй хэмжүүр нь болж байдаг байна. Бүр тодруулан хэлбэл, эдүгээгийн бид уйгур бичгийг хэл аялгуундаа тохируулан авч хэрэглэсэн тэр үеийн монгол хэлний дуудлагаар бичиж, XXI зууны үеийн монгол хэлний амид дуудлагаар ярьж байна гэсэн үг. Монгол бичигийн хэлээр илэрч байгаа минган жилийн өмөнөх монгол хэл, өнөөгийн амид ярианы хэлээр илэрч байгаа орчин цагийн монгол хэл хоёрын хоорондох ялгаа зөрөө нь өнгөрсөн минган жилийн хугацаанд монгол хэлний авианы бүрэлдэхүүн, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр хэрхэн хувиссаныг бодитоор зааж байгаа хэрэг. Тийнхүү минган жилийн түүхтэй монгол бичигийн хэлэнд эртний монгол хэлний авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр хадгалагдан үлдсэн ганцхан үг нь ч гэсэн минган жилийн настай археологийн олдвортой эн сацуу үнэт дурасхал болно.

Бидний өвөг дээдэс ийм эртний уламжилалтай, ийм үнэ цэнэтэй үсэг бичигээ нандигнан хадгалсаар ирсэн бөгөөд харин өнгөрсөн зууны үеэс Ар, Өвөр Монголын аль алинд нь бичигийн хэлээ ярианы хэлэндээ ойртуулах гэсэн өнгөц гажуудал бий болсоныг яасан ч зөвдхөх аргагүй.

Сүүлийн жилүүдэд Монгол улс болон Өвөр Монголд монгол бичигийн зөв бичих дүрэмийн хэд хэдэн толь бичиг нийтлэгдэн мөрдөгдөж байна. Тухайлбал, Монгол улсад Ж. Надмид, *“Монгол бичгийн зөв бичих толь бичиг”* (1990, 2024), Б. Шагжийн *“Монгол үсгийн дүрмийн толь”* (1997), Ш. Чоймаа нарын *“Монгол хэлний хэл зүйн толь бичиг”* (2005), *“Монгол хэлний хадмал толь”* (2020), Д.

Пүрэвдоржийн “*Ариутган шүүсэн монгол бичгийн хадмал тод толь*” (2024), Өвөр Монголд Бүрэнтөгсийн “*Монгол хэлний зөв бичлэг, зөв дуудлагын толь*” (1977), “*Монгол зөв бичлэгийн толь*” (1999, 2012, 2021), *Монгол хэлний дан үгсийн дүрэмжүүлсэн бичлэгийн тайлбар*” (2020) зэрэг толь бичигүүд гарчээ. Тэдгээр толь бичигүүд монгол бичгийн сонгодог уламжилалаа голлон баримталсан боловч зарим үгийн бичлэг болон нөхцөл, дагаварын бүтэцийг гажуудсан жишээ ч бас цөөнгүй байна. Бид энд монгол бичгийн зөв бичих зүйн зарим толь бичиг болон өргөн хэрэглээний ном зохиолуудад нийтлэг тохиолдож байгаа зарим нэгэн гажуудалын талаар товч дурдая.

1. **Үгийн язгуур, үндэсийн бүтэц эвдэрсэн нь.** Залгамал бүтэцтэй монгол хэлний үгийн язгуур, үндэсийн бүтэц нь ямар ч тохиолдолд эвдэрэхгүй хадгалагдах хатуу тогтсон зарчимтай бөгөөд тэр зарчимаа олон зуун жил нарийн чанд баримталсаар ирсэн түүхтэй. Харин сүүлийн үед зарим үгийн язгуур, үндэсийн бүтэцийг ярианы хэлэнд ойртуулан засварлах өнгөц хандлага ажиглагдах боллоо. Үүнтэй холбогдуулан үгийн язгуур, үндэсийг эвдэж бичсэн зарим нийтлэг жишээнээс төлөөлөл болгон цөөн жишээ татая.

Монгол бичгийн толь бичигүүд болон ном зохиолд ‘*нааш*’, ‘*нааш*’ гэсэн үгийг *ᠨᠠᠰᠢ* (*nasi*), *ᠴᠠᠰᠢ* (*časi*) гэж бичих болжээ. Гэтэл тэдгээр нь XIII-XIV зууны үеэс *ᠨᠠᠶᠠᠳᠤ* (*naγadu*) ‘наад’, *ᠴᠠᠶᠠᠳᠤ* (*čaγadu*) ‘цаад’, *ᠨᠠᠶᠠᠨ* *ᠠ* (*naγan-a*) ‘наана’, *ᠴᠠᠶᠠᠨ* *ᠠ* (*čaγan-a*) ‘цаана’, *ᠨᠠᠶᠠᠶᠤᠷ* (*naγaγur*) ‘наагуур’, *ᠴᠠᠶᠠᠶᠤᠷ* (*čaγaγur*) ‘цаагуур’ гэх мэт *ᠨᠠᠶᠠ* - (*naγa-*) / *ᠴᠠᠶᠠ* - (*čaγa-*) гэсэн үүсмэл язгууртай байсан тул тэдгээрийг *ᠨᠠᠶᠠᠰᠢ* (*naγasi*), *ᠴᠠᠶᠠᠰᠢ* (*čaγasi*) гэж бичвэл зохино. Түүгээр ч барахгүй, сонгодог монгол бичигт зүг чиг заасан утгыг - *ᠨᠠᠶᠠ* (-*γsi*) / *ᠴᠠᠶᠠ* (-*gsi*) дагавараар илэрхийлж, *ᠶᠤᠨᠠᠶᠠᠨᠠᠰᠢ* (*qoyinaγsi*), *ᠶᠤᠨᠠᠶᠠᠰᠢ* (*uruγsi*), *ᠳᠡᠭᠡᠭᠡᠭᠢ* (*degegsi*), *ᠳᠣᠷᠤᠶᠠᠰᠢ* (*doruγsi*) хэмээн бичдэг уламжилалын дагуу дээрхи хоёр үгийг *ᠨᠠᠶᠠᠶᠠᠰᠢ* (*naγaγsi*), *ᠴᠠᠶᠠᠶᠠᠰᠢ* (*čaγaγsi*) гэж бичих нь бүр ч зөв болно.

Дээрхитэй төстэй өөр хэдэн жишээ дурдая. Монгол бичгийн хэлний *ᠬᠡᠮᠡ* (*keme-*) гэсэн үйл үгийн *ᠬᠡᠮᠡᠵᠢ* (*kemejü*), *ᠬᠡᠮᠡᠬᠦ* (*kemekü*), *ᠬᠡᠮᠡᠭᠢᠰᠢᠨ* (*kemegsen*) зэрэг хэлбэрийг *ᠬᠡᠮᠡᠵᠢ* (*gejü*), *ᠬᠡᠮᠡᠬᠦ* (*gekü*), *ᠬᠡᠮᠡᠭᠢᠰᠢᠨ* (*gesen*) гэх мэтээр хялбарчилан бичих болжээ. Мөн *ᠠᠶᠤ* ~ *ᠠᠶᠤ* (*ayu-*) ~ (*ayi-*) || *ᠶᠤᠶᠤ* ~ *ᠶᠤᠶᠤ* - (*γyūyū*) ~ (*γyūyi-*) || *ᠶᠢᠳᠤᠶᠠᠨ* ~ *ᠶᠢᠳᠤᠶᠠᠨ* (*iduyān*) ~ (*uduyān*) || *ᠬᠢᠮᠤᠰᠤᠨ* ~ *ᠬᠢᠮᠤᠰᠤᠨ* (*kimusun*) ~ (*qimusu*) || *ᠨᠢᠳᠤᠷ* ~ *ᠨᠢᠳᠤᠷ* (*nidur-*) ~ (*nudur-*) || *ᠨᠢᠮᠭᠢᠨ* ~ *ᠨᠢᠮᠭᠢᠨ* (*nimgen*) ~ (*ninggen*) || *ᠣᠪᠤ* *ᠠ* ~ *ᠣᠪᠤ* (*obu*) ~ (*obuy-a*) || *ᠰᠢᠭᠦᠰᠦ* ~ *ᠰᠢᠭᠦᠰᠦ* (*sigüsü*) ~ (*šügüsü*) гэх мэтээр үгийн язгуурын бүтэцийг эвдэж бичсэн шинэ хувилбарууд олон гарсаныг дурдаж болно. Түүнчилэн урт эгшиг үүсэн бүрдэхээс өмөнө хэвшин тогтсон *ᠠᠶᠠ* (*aγā*), *ᠠᠭᠦ* (*egē*), *ᠠᠶᠤ* (*aγū*), *ᠠᠭᠦ* (*egü*) гэх мэт цогцыг дан эгшиг үсэгээр тэмдэглэсэн жишээ ч нилээд тохиолдож байна.

- ᠳᠠᠬᠢ* daki < Мо. *ᠳᠠᠶᠠᠬᠢ* (*dayaki*) ‘*даахь*’
- ᠬᠢᠷ* *ᠡ* kür-e < Мо. *ᠬᠢᠷᠢᠶᠡ* *ᠡ* (*küriy-e*) ‘*хүрээ*’
- ᠶᠠᠨ* *ᠠ* qan-a < Мо. *ᠶᠠᠮᠢᠶᠠᠨ* *ᠠ* (*qamiγ-a*) ‘*хаана*’
- ᠰᠠᠷᠠᠯ* saral < Мо. *ᠰᠠᠶᠠᠷᠠᠯ* (*sayaral*) ‘*саарал*’

Бас зарим үгийн бичлэгийг түүхэн үүднээс эргэн харж, эргэцүүлэн бодмоор зүйл ч бас байна. Жишээлвэл, монгол бичгийн толь бичигүүд болон ном зохиолд ‘*odō*’ гэдэг үгийг *ᠣᠳᠤ* (*odu*) хэмээн бичиж хэвшсэн нь ‘*od*’ гэсэн үгтэй адил бичигдэх болжээ. Уйгуржин монгол бичгийн эртний дурасхалууд болон хожуу үеийн түүхэн сурвалж бичигүүдэд тухайн үгийг зөвхөн *ᠡᠳᠦᠭᠡ* (*edüge*) гэсэн үгээр илэрхийлсэн буй. Харин ‘*odō*’ гэдэг үг нь эртний монгол хэлний бичгийн дурасхалууд болон хожуу үеийн түүхэн сурвалж бичигүүдэд огт тохиолддоггүй,

зөвхөн ярианы хэлэнд өргөн хэрэглэгддэг бөгөөд дээр дурдсан *edüge* хэмээх үгийн хувилбар юм. Хэрэв энэ хувилбарыг бичигийн хэлэндээ хэрэглэе гэвэл  $\text{ᠣᠳᠣᠭᠦᠭᠡ} \text{ᠠ}$  (*oduy-a*) гэж бичвэл зохино. Эсвэл '*edüge*' гэсэн үгийг бичигийн хэлэндээ тууштай хэрэглээд, '*odō*' гэсэн үгийг зөвхөн ярианы хэлэндээ хэрэглэж болох юм.

2. **Үг холбох нөхцөлийн бүтэц эвдэрсэн нь.** Монгол бичигийн хэлний нэр, үйл үгийн холбох нөхцөлүүд нь олон жилийн турш уулын бүтэцээ тогтвортой хадгалсаар иржээ. Гэтэл монгол бичигийн одоогийн бодит хэрэглээн дээр харьяалах тийн ялгалын  $\text{ᠡ}$  (*-u/-ü*) нөхцөлийг  $\text{ᠡᠢ}$  (*-ai/-ei*)-гээр, гарах тийн ялгалын  $\text{ᠡᠠ}$  (*-aᠰ/-eᠰ*) нөхцөлийг  $\text{ᠡᠰ}$  (*-as/-es*)-ээр сольж бичсэн жишээ цөөнгүй тохиолдож байна.

Тийн ялгалын нөхцөлүүд

- $\text{ᠡᠷᠲᠡᠨᠢ}$  ertenei [ $\text{ᠡᠷᠲᠡᠨᠢ} \text{ᠡ}$  (erten-ü)] 'эртний'
- $\text{ᠮᠠᠨᠠᠢ}$  manai [ $\text{ᠮᠠᠨᠠᠢ} \text{ᠡ}$  (man-u)] 'манай'
- $\text{ᠨᠠᠳᠠᠰᠠ}$  nadasa [ $\text{ᠨᠠᠳᠠᠰᠠ} \text{ᠠᠰ}$  (nada-aᠰa)] 'надаас'
- $\text{ᠲᠡᠨᠳᠡᠰᠡ}$  tendese [ $\text{ᠲᠡᠨᠳᠡᠰᠡ} \text{ᠡᠰ}$  (tende-eᠰe)] 'тэндээс'

Сонгодог монгол бичигийн хэлний орших орон заасан  $\text{ᠳᠠ}$  (*-da/-de ~ -ta/-te*) нөхцөлийн бүтэц болон үүрэг нь хэвээр байсаар байтал түүний оронд өгөх тийн ялгалын утга бүхий  $\text{ᠳᠤ}$   $\sim$   $\text{ᠳᠦ}$  (*-du/-dū ~ -tu/-tū*) нөхцөлийг хэрэглэж байгаа нь зохисгүй.

Үйл үгийн холбох нөхцөлүүд

- $\text{ᠵᠠᠢ} \text{ᠵᠡᠢ}$  (-jai/-jei  $\sim$  čai/-čei)  $\text{ᠵᠠᠢ} \text{ᠵᠡᠢ}$  [ $\text{ᠵᠠᠢ} \text{ᠵᠡᠢ}$  (-juqui /-jüki  $\sim$  čuqui /-čüki)]
- $\text{ᠯᠠ} \text{ᠯᠡ}$  (-l-a/-l-e) [ $\text{ᠯᠠ} \text{ᠯᠡ}$  (-luᠭ-a / -lüge)]
- $\text{ᠮᠤ} \text{ᠮᠦ}$  (-n-a/-n-e) [ $\text{ᠮᠤ} \text{ᠮᠦ}$  (-mu /-mü  $\sim$  -mui / -müi)  $\sim$   $\text{ᠨᠠᠮ}$  (-nam / -nem)]

3. **Бусад зарим дагаварын тухай.** Монгол бичигийн хэлний ерөнхийлөн хамаадуулах утгатай  $\text{ᠶᠢᠨ}$   $\text{ᠠᠨᠤ}$  (*inu / anu*) гэсэн нөхцөл нь анхандаа өмөнөх үгтэйгээ ганц, олон тоогоор зохицон ордог байгаад хожим ганц, олон тооны утгаа алдаж, өмөнөх үгтэйгээ эр, эмээрээ зохицон ордог болсон байна. Гэтэл сүүлийн үед дээрхи нөхцөлийн *a/-e*- гэсэн язгуур бүтэцийг нь орхиж, өмөнөх үгийнх нь эр, эмийг харгалзалгүй гагцхүү  $\text{ᠨᠢ}$  (*ni*) гэсэн бүтэцтэйгээр бичих болжээ. Хойшид эдгээр нөхцөлийг хуучин уламжилалынх дагуу өмөнөх үгийнх нь эр, эмийг харгалзан  $\text{ᠶᠢᠨ}$   $\text{ᠠᠨᠤ}$  (*anu / inu*) хэмээн бүтэн бичих нь зохистой. Дээрхээс гадна  $\text{ᠨᠢ}$  (*ni*) нөхцөлийг  $\text{ᠳᠤ}$  (*-du(r)/-dū(r)*) нөхцөлтэй холбож,  $\text{ᠳᠠᠨᠢ}$  (*duni/-dūni*), хамаадуулах утгатай  $\text{ᠬᠢ}$  (*ki*) нөхцөлтэй холбож,  $\text{ᠬᠢᠨᠢ}$  (*kini*) гэх мэт нийлмэл бүтэцтэй шинэ нөхцөл үүсгэсэн нь нэн хачирхалтай.

Энэ мэтээр язгуур-дагавар, үндэс-нөхцөлийн бүтэцийг дураараа өөрчилөн бичихийг аль нэгэн байгуулга, хэн нэгэн дарга удирдан зохион байгуулаагүй, харин бичигийн хэлээ ярианы хэлэндээ ойртуулах гэсэн хэрэглэгчидийн дөхөмчилөх хандлагын үр дүн юм. Олон зуун жилийн уламжилалтай сонгодог бичигийн хэлнийхээ тогтсон дүрэмийг зөрчиж, ярианы хэлэндээ ойртуулах гэсэн энэхүү хандлага нь монгол бичигийн хэлний хөгжилийн түүхэнд гарсан дэвшил бус, харин цаг зуурын шинжтэй ухаралт юм.

Үеэс үед боловсорон төгөлдөржсөөр сонгодог бичигийн өндөр зиндаанд хүрсэн монгол бичигээ хайрлан хамгаалж, нандигнан хадгалах үүрэг монгол хүн бүхэнд байх ёстой, харин түүнийг өөрчилөн засварлах эрх хэнд ч байхгүй гэдэгийг сануулмаар байна. Ацаг шүд, орхиц цацлага бүрт нь монгол хэлний бүтэц, тогтолцоо сүншиглэн шингэсэн сонгодог монгол бичигийнхээ уламжилалт дүрэм зүйг хүн бүр хичээнгүйлэн мөрдөх нь үндэснийхээ бичгийг илүү өргөн хүрээнд сэргээн хэрэглэж буй энэ цаг үед чухалаас чухал болж байна.

## **Abstract**

The Written Mongolian language originated from the ancient Uighur script, which originally contained only 14 letters. The Mongols adopted and modified it based on their own dialect, expanding it to a total of 123 syllabic letters by the beginning of the 14th century. A number of inscriptions, xylographs, and manuscripts written in this script have been preserved. Since then, the Mongols have continually refined the script, developing it into a comprehensive written language and producing hundreds of works, including Buddhist teachings, classical works of Buddhist philosophy, linguistic studies, historical records, legal texts, literature, and official records. All these documents are precious monuments of Classical Mongolian.

However, since the last century, there has been a tendency to alter the traditional orthography to reflect spoken pronunciation. As a result, the structure of roots, stems, suffixes, and affixes has been disrupted. It is therefore essential to preserve and strictly maintain the traditional orthography of Classical Mongolian.